

ТУШААЛ

Журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай

Төв банк (Монголбанк)-ны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, 5 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт, 11 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 1 дэх заалт, 19 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг, 28¹ дүгээр зүйлийн 2 дахь заалт, Банкны тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийн 16.1.1, 16.1.2 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэг, 38 дугаар зүйлийн 38.1, 38.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-138 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам”-д дор дурьдсан байдлаар өөрчлөлт оруулсугай:

1.1 Журмын 3.4-т заасан түргэн борлогдох хөрөнгөд “Нийслэлийн үнэт цаас”-ыг нэмэх;

1.2 Журмын 1 дүгээр хавсралтын Б хэсгийн 11.1²-т "Нийслэлийн үнэт цаас"-ыг нэмж, эрсдэлээр жигнэх хувийг 20 хувиар тогтоох;

1.3 Журмын 1 дүгээр хавсралтын Б хэсгийн 14.5-д "Зээлээс бусад чанаргүй актив"-ыг нэмж, эрсдэлээр жигнэх хувийг 150 хувиар тогтоох.

2. Энэ тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар (Ц.Нарандалай)-т үүрэг болгосугай.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Б.ЛХАГВАСҮРЭН